



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 188

Номгон

Үндсэн хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2, 2.4 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2010 онд ашиглалтад орсон 21-71БНА улсын дугаартай 16 913 636,37 төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн автомашины худалдах доод үнийг 1,5 сая төгрөгөөр, Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд бүртгэлтэй 2011 онд ашиглалтад орсон 25-84БНХ улсын дугаартай 16 100 000 төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн автомашины худалдах доод үнийг 1,3 сая төгрөгөөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн хөрөнгөд 2012 онд ашиглалтад орсон 44-26БНХ улсын дугаартай 10,500,000 төгрөгийн анхны өртөгтэй, Crown маркийн автомашины худалдах доод үнийг 1.5 сая төгрөгөөр, Байгаль орчин аялал жуулчлалын газрын хөрөнгөд бүртгэлтэй 2007 онд ашиглалтад орсон 13431000 төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн 69-36БНА улсын дугаартай автомашины худалдах доод үнийг 1,0 сая төгрөгөөр тус тус тогтоож нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Заг сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1970 онд ашиглалтад орсон 18592000 төгрөгийн анхны үнэтэй 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 1 670 821,7 төгрөгийн үлдэх өртөгтэй хуучин цэцэрлэгийн барилгыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 87 дугаар тогтоолоор 10,0 сая төгрөгөөр худалдах шийдвэр гарч 2 удаа нээлттэй дуудлагын худалдаа зохион

байгуулсан боловч оролцогч ирээгүй тул худалдах доод үнийг 6,0 сая төгрөгөөр тогтоосугай.

3. Заг сумын Цэцэрлэгийн барилга /газрын хамт/, автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11.00 цагт аймгийн Орон нутгийн өмчийн газрын 114 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлсүгэй.

4. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай:

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 87 дугаар тогтоолын нэг дэх заалтыг хүчингүй болгосугай.

6.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР